



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2000 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд /тэтгэврийн даатгал/ албан журмаар даатгуулах шимтгэлийн доод хэмжээг сарын 40 000 /дөчин мянга/ вонноос багагүй байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1-д зааснаас бусад нөхцөлөөр Бүгд Найрамдах Солонгос Улсад оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалд /тэтгэврийн даатгал, тэтгэмжийн даатгал, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал/ сайн дураар даатгуулах шимтгэлийн доод хэмжээг сарын 40 000 /дөчин мянга/ вонноос багагүй байхаар тогтоосугай.

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Д.Зоригт/-т үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2014 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай” 19, 20 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэ тогтоолыг 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

6. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Р.Отгонжаргал/-нд даалгасугай.

ДАРГА С. ШИНЗОРИГ

